

Мангагаар дамжуулан мэдэж авцгаая

Цүкими (Сар харах)



Намар болоход, шөнийн тэнгэрт хөвөх сар үзэсгэлэнтэй харагддаг учраас, Японд эртнээс “Цүкими (Сар харах)” гэдэг ёс заншил байдаг. Нэг жилд хамгийн үзэсгэлэнтэй харагддаг сар нь “Арван тавны шөнө” (хуучин тооллын 8-р сарын 15-ны өдөр) харагддаг сар гэгддэг. Намрын ургац хураалтын баярыг тэмдэглэн, талархал илэрхийлэх арга хэмжээ болгон, Япон пампас өвсийг тавьж, Цүкими данго идэн, үзэсгэлэнт сарыг биширдэг. Мөн Японд сарны гадарга дээрх хар хээ нь мочи-цүки (жигнэсэн цагаан будаа цохиж нухах) хийж байгаа туулай шиг харагддаг бөгөөд дэлхий даяар сартай холбоотой олон үлгэр, домог байдаг бололтой. 2025 оны “Арван тавны шөнө” нь 10-р сарын 6-ны өдөр. Та бүхнийг жилд хамгийн үзэсгэлэнтэй сарыг харж баясахыг урьж байна.

“とも/Томо” нь, Японд амьдрахад хэрэг болох мэдээлэл, Япон хэл сурахад хэрэг болох зүйлс зэргийг, дуудлагыг нь хадсан Япон хэл болон гадаадын 9 орны хэл (Вьетнам, Хятад, Филиппин, Индонези, Тайланд, Камбодж, Мьянмар, Монгол, Англи) дээр гаргадаг.

(<https://www.jitco.or.jp/ja/tomo/>)





Нягтлаарай! Унадаг дугуйны замын дүрэм

2026 оны 4-р сараас эхлэн хууль зөрчсөн жолоодлогод зөрчлийн төлбөр ноогдуулдаг болно.



Дугуйг тээврийн хэрэгсэл болгон ашигладаг хүн болон байдаг болов уу. Дугуйны замын ослоос сэргийлэхийн тулд зөв замын дүрмийг дахин нэг нягталж үзэцгээе.

Дугуй унахдаа ~Мөрдөх 5 чухал зүйл~

- 1 Автомашины замын зүүн талаар зорчоорой. Унадаг дугуй нь автомашины төрөлд хамрагддаг тул, зарим хамааралгүй тохиолдлыг үл тооцон, автомашины замын зүүн талаар зорчих ёстой. Дугуйгаар зорчих боломжтой явган хүний зам дээр ч гэсэн явган хүн түрүүнд нь зорчино. Дугуйгаар зорчихдоо, автомашины замд ойрхон талаар нь хурдаа сааруулж зорчоорой.
- 2 Замын уулзвар дээр, гэрлэн дохио болон “Зогсох тэмдэг”-ийг дагаж мөрдөн, аюулгүй байдлыг магадлаарай.
- 3 Орой, шөнийн цагаар зорчихдоо, дугуйныхаа гэрлийг заавал асаагаарай.
- 4 Согтууруулах ундаа уусны дараа дугуй унаж болохгүй.
- 5 Ослын улмаас үүсэх хохирлыг багасгахын тулд, толгойны хамгаалалт өмсөхийг хичээгээрэй.



Дагаж мөрдөхгүй бол зөрчлийн төлбөр ноогдоно!



Эдгээр дүрмийг баримтлаагүй тохиолдолд хариуцлага тооцдог бөгөөд 2026 оны 4-р сараас эхлэн, автомашин, мотоциклын нэгэн адилаар, дүрэм зөрчсөн этгээдэд зөрчлийн төлбөр хураалгахыг шаардах хяналт хийгдэх болно. Тухайлбал, гар утасны “Анхаарал сарнисан жолоодлого”-д 12,000 иен, орой, шөнийн цагаар гэрлээ асаалгүй зорчсон тохиолдолд 5,000 иен гэх зэргээр төлбөр төлөх шаардлагатай болно. Замын дүрмийг чандлан баримталж, аюулгүй зорчихыг хичээгээрэй.

出典：「広報けいしちょう」春号（第111号）より抜粋し、JITCOが作成


Үзэж суралцах замын дүрэм

JITCO сургалтын материалын онлайн дэлгүүрт DVD “Q&A-аар үзэх Японы замын аюулгүй байдал ~Явган зорчих болон дугуйгаар зорчих дүрэм~”-ийг худалдаалж байна. Япон, Хятад, Англи, Индонези, Вьетнам гэсэн 5 хэлээр бичлэг хийсэн. Та бүхнийг үзэхийг урьж байна.



Q&Aで覚える日本の交通安全
～歩行と自転車のルール～

Гамшигт “бэлэн” үү?



Гамшиг хэзээ, хаана гарахыг мэдэх боломжгүй тул ердийн үеэсээ бэлтгэлтэй байх нь чухал юм. Гамшгийн үед авч гарах ёстой юмнуудаа урьдчилан үүргэвчинд хийж, шууд авч гарахад бэлэн байлгаарай.

Гамшигт бэлтгэлтэй байх юмнуудыг базаагаарай.

- ✓ **Ундны ус**
- ✓ **Хүнс** Хүнсэнд хэрэглэх лаазалсан хүнс, хатаасан талх, жигнэмэг г.м гал байхгүй тохиолдолд ч идэх боломжтой юмнуудыг базаагаарай.
- ✓ **Ахуйн хэрэглээний зүйлс** Гар чийдэн, зөөврийн газан плетка, зөөврийн баттерей г.м
- ✓ **Ариун цэврийн хэрэгсэл** Дотуур хувцас, нойтон салфетка, шүдний сойз, шүдний оо, амны хаалт/маск, ариун цэврийн хэрэглэл зэрэг
- ✓ **Анхны тусламжийн хэрэгсэл** Шархны лент, ариутгагч шингэн, өргөн хэрэглээний эм зэргийг хийвэл сайн болов уу.



Үүнийг мөн нягтлаарай. —“Дүрвэх газар” ба “Хоргодох байр”—

“Дүрвэх газар” гэдэг нь, дүрвэн зугатах газар.

Том хэмжээний гамшиг гарсан тохиолдолд түр дүрвэх газар. Сургуулийн талбай, цэцэрлэгт хүрээлэн зэргийг дүрвэх газар болгон оноосон байдаг.

“Хоргодох байр” гэдэг нь, дүрвэсний дараа амьдрах боломжтой газар.

Том хэмжээний газар хөдлөлт, тайфун зэргийн улмаас гэртээ байх нь аюултай тохиолдол болон газ, цахилгаан, ус тасарч, оршин суугаа газраа амьдрахад бэрхшээлтэй тохиолдолд хэсэг хугацаанд хоргодох байранд амьдрах боломжтой. Хоргодох байрыг хэн ч ашиглаж болох боловч, тогтсон дүрмийг нь заавал баримтлаарай.

Дүрвэх газар, хоргодох байрыг оршин суугаа нутгийн Захиргааны газрын цахим хуудас болон “Аюулын зураглал” зэргээс харах боломжтой.

政府広報オンライン（<https://www.gov-online.go.jp/article/201108/entry-8072.html>）より抜粋し JITCO が作成

とも

2025年10月 秋季号

2025年10月1日発行

発行

電話

JITCO ホームページ

公益財団法人 国際人材協力機構 (JITCO)

総務部広報室

〒108-0023

東京都港区芝浦2-11-5

五十嵐ビルディング

03-4306-1166 (ダイヤルイン)

<https://www.jitco.or.jp/>



jitco.official



@jitco_official